



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/303

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 9.3.1, 9.3.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсролын байгууллагад хэрэглэгдэж байгаа химийн хорт болон аюултай бодисын нэдсэн бүртгэл, судалгаа хийж стандартын шаардлага хангаагүй, хугацаа нь дууссан, зориулалтын бус байр, саванд хадгалагдаж байгаа химийн бодисыг тээвэрлэх, устгах, хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулсан, учруулж болзошгүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэж холбогдох арга хэмжээ авахуулах, химийн хорт болон аюултай бодисын физик, химийн болон хор, аюулын шинж чанар, осол, эрсдэлийн үед авах арга хэмжээ, аюулгүй ажиллагааны зөвлөмж, санамж боловсруулж, багш, сурагчдыг мэдээллээр хангах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Ганзориг (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

Гишүүд:

Б.Даваасүрэн (Мэргэжлийн хяналтын газрын Байгаль, орчны хяналтын улсын байцаагч)

Л.Бямбасүрэн (Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах Улсын хяналтын ахлах байцаагч)

Н.Болоржаргал (Байгаль, очин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Нарийн бичигийн дарга:

Ш.Энх-Үрэл (Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтэн)

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Хүний эрхийн үндэсний комиссын зөвлөмжийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулж тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (Ц.Ганзориг)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ч.Ганбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН